

8 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл:

Монгол Улсын Сүхбаатар, Дорнод, Хэнтий аймаг, БНХАУ-ын ӨМӨЗО-ы Шилийн гол, Тунляо, Улаан хад хот хоорондын бүс нутгийн хамтын ажиллагааны зургаан талт тавдугаар форум наймдугаар сарын 07-09-нд Сүхбаатар аймагт зохион байгуулагдлаа. “Зүүн бүсийн хөгжлийн гарц-Хамтын хүч” тав дахь удаагийн форумаар бүс нутгийн хөгжлийн талаар хэлэлцэн, харилцан мэдээлэл солилцож, цаашдын хамтын ажиллагааны санамж бичгийг байгууллаа. Уг форумд оролцогсод хамтын ажиллагаа шинэ шатанд гарсан, томоохон төсөл хөтөлбөрүүдийн эхлэл тавигдсан, өндөр үр ашигтай уулзалт болсон гэдгийг онцоллоо.

Хоёр. Хууль, эрх зүйн чиглэлээр

Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй “Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”-ийн хүрээнд “Түр хамгаалах байр”ны үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, түр хамгаалах байр байгуулах ажлын бэлтгэл, одоогийн нөхцөл байдалтай газар дээр нь танилцах зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны ахлах мэргэжилтэн цагдаагийн дэд хурандаа М.Отгонжаргалаар ахлуулсан ажлын хэсэг ирж аймгийн ИТХ-ын ажлын алба, Хууль эрх зүйн хэлтэс болон холбогдох байгууллагын албан тушаалтнуудтай уулзалт зохион байгуулан өргөтгөл хийх барилга, зураг төсөвтэй танилцан үүрэг даалгавар өглөө.

Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Иргэний зөвлөл нь энэ сарын 15, 16-ны өдрүүдэд Баруун-Урт, Дарьганга сумдад ажиллаж, иргэд, төрийн албан хаагчидтай уулзалт, ярилцлага хийсэн ба тус зөвлөлөөс шаардсан мэдээ, тайланг гаргаж хүргүүлээ.

Цагдаагийн байгууллага: Сүхбаатар аймгийн хэмжээнд 2019 онд мотоциклтой холбоотой зам тээврийн осол 13 бүртгэгдсэн бөгөөд энэ төрлийн ослыг бууруулах зорилгоор аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгаас "Мотоцикл" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж байна. Нэгдсэн арга хэмжээний хүрээнд замын цагдаагийн тасгийн алба хаагчид мотоцикл болон мопедын жолооч нарын гаргадаг нийтлэг зөрчилтэй холбогдуулан замын хөдөлгөөний дүрэм, аюулгүй байдлаа хангах талаар мэдээлэл өглөө.

Мөн Цагдаагийн газраас интернет кафе, цахим тоглоомын газруудын стандарт шаардлагад хяналт тавих зорилгоор "Цахим тоглоом-Хяналт" хэсэгчилсэн арга хэмжээг аймгийн Мэргэжлийн хяналтын газартай хамтран зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд Баруун-Урт сумын нутаг дэвсгэрт орших 5 цахим тоглоомын газар, 1 интернет кафены үйл ажиллагааг шалгаж, стандарт, эрүүл ахуйн шаардлага болон Засгийн газрын 2013 оны 410 дугаар тогтоолын хэрэгжилт бүрэн хангагдаагүй 1 газрын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоож, 2 газарт хуулийн дагуу арга хэмжээ тооцох шийдвэрийг гаргалаа. Мөн үйл ажиллагаа явуулахгүй байгаа 2 цахим тоглоомын газрыг гадна хаягаа авах чиглэл, үүргийг өгч ажилласан.

Цагдаагийн байгууллагын мэдээллийн сангийн бүртгэл хяналтын санд нэмэлт баяжилт хийх, аймгийн хэмжээнд барилга байгууламж шинээр барьж буй байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд тавих хяналтыг сайжруулах, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор "Бүртгэл хяналт" хэсэгчилсэн арга хэмжээг зохион явуулж байна. Арга хэмжээний хүрээнд 6 аж ахуйн нэгж, тэдгээрийн ажилтнуудыг бүртгэл судалгаанд авч, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр "Албан мэдэгдэл, зөвлөмж"-ийг бичиж хүргүүлээд байна.

Гурав. Боловсрол, соёл, спорт, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд

Боловсролын чиглэлээр: “Сургуулийн өмнөх, бага, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэнд дэмжлэг үзүүлэх арга зүй” үндэсний сургалтыг аймгийн

хэмжээнд зохион байгуулж 900 гаруй багш, удирдах ажилтнууд хамрагдсан ба 31 сургагч багш чиглүүлэгчээр ажиллаж 4 өдөр зохион байгуулагдсан.

Аймгийн Багш нарын бага хурлыг зохион байгуулж 100 гаруй багш удирдах ажилнууд оролцон 2019-2020 оны хичээлийн жилийн зорилтоо дэвшүүлэн баталлаа.

Хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлын хүрээнд сургууль, цэцэрлэгүүдийн засварын ажлыг дуусгах, шинээр элсэх сурагчдын тоог нарийвчлан гаргах, шинээр орж буй багш ажилтнуудын сонгон шалгаруулалтыг зохион байгуулах талаар ажлын чиглэлийг боловсролын байгууллагуудад өгч ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/472 дугаар захирамжаар Түвшинширээ, Дарьганга сумын сургуулиудыг 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн 12 жилийн сургалттай болгохоор шийдвэрлэлээ. Ингэснээр тус аймгийн 13 сумын 16 ерөнхий боловсролын сургуулийн 11 нь 12 жилийн сургалттай болж улмаар сурагчид тухайн орон нутагтаа бүрэн дунд боловсрол эзэмших нөхцөл боломж бүрдэж байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр: Аймгийн ИТХ-ын 2018 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Аз жаргалтай гэр бүл” дэд хөтөлбөр, Гэр бүлийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, зорилтот бүлгийн өрхийн гишүүдийг амьжиргааг дэмжих зорилгоор зорилтот бүлгийн 120 өрхөд иж бүрэн гэр олгох ажлыг зохион байгууллаа.

Соёл урлагийн чиглэлээр:

Угсаатны зүйн музей: Монголын үндэсний музейгээс эрхлэн гаргадаг “Музейн мэдээлэл” сэтгүүлд “Нандин өв” мөнгөн урлалын үзэсгэлэнгийн талаар мэдээ бэлтгэж явууллаа.

Аймгийн Угсаатны зүйн музей үүсэн байгуулагдсаны 70 жилийн ойн хүрээнд ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнтэй хамтран ажиллахаар болсон ба энэ хүрээнд Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, түр үзэсгэлэн гаргах, зохион байгуулахаар болж бэлтгэлийг ханган ажиллаж байна.

Хөгжимт жүжгийн театр: Монгол улс БНХАУ-тай дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойн арга хэмжээний хүрээнд “Дарьганга нутгийн дуулал” тоглолтыг БНХАУ-ын ӨМӨЗО-ны Улиастай хотод 40 хүний бүрэлдэхүүнтэйгээр 08 сарын 14-19-ний өдрүүдэд амжилттай тоглосон.

Нийтийн номын сан: Баруун-Урт сумын 7-р багтай хамтран Аймгийн Нийтийн номын сангаас нутгийн зохиолчдын номын худалдаа, зөөврийн номын сангийн үйлчилгээг иргэдийн хэрэгцээт болон хүүхдийн номоор хүргэж, уншигчдад карт нээж, хүүхдүүдийн дунд "АХА" тэмцээн, 7-р багийн албанаас хүүхдүүдийн дунд зургийн тэмцээнийг зохион байгуулж, шалгарсан хүүхдүүдэд ном дурсгав. Энэхүү арга хэмжээнд нийт 50 гаруй хүн хамрагдлаа.

Эрүүл мэндийн чиглэлээр: Тус аймгийн Дарьганга суманд 10 ортой эрүүл мэндийн төвийн шинэ барилга ашиглалтад орлоо. Уг барилгыг улсын төвсийн 915.6 сая төгрөгийн санхүүжилтээр "Хөх хайрхан трейд" ХХК гүйцэтгэсэн ба гэрээний хугацаанаас 2 сарын өмнө барилгыг улсын комисст хүлээлгэн өглөө.

ЭМЯ-аас зарласан “Тэмбүүг устгая” аяны хүрээнд нийт 1151 хүнийг тэмбүүгийн үзлэг шинжилгээнд хамруулж илэрсэн өвчлөл болон хавьтлыг илрүүлж 100 хувь эмчилгээнд хамрууллаа Мөн 2019 онд БЗДХ-аас сэргийлэх ажлын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж ЭМЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн газарт хүргүүлээ.

Сүхбаатар аймгийн эрүүл мэндийн салбарын эмч, сувилагч, ажилчин албан хаагчдыг спортоор тогтмол хичээллүүлэх, эрүүл чийрэг аж төрж, халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх зорилгоор Эрүүл мэндийн салбарын спортын 3 дугаар наадмыг зохион байгуулж 19 байгууллагын 210 эмч эмнэлгийн мэргэжилтнийг хамрууллаа.

Баруун-Урт сумын хөдөөгийн багт Явуулын амбулаторийн үзлэг шинжилгээг 5 газарт зохион байгуулж нийт 318 иргэнд дотрын эмчийн үзлэг, ЭХО, БЗДХ, Өрхийн эрүүл мэндийн төвийн бага эмчийн урьдчилан сэргийлэх үзлэг зэрэг амбулаторийн үйлчилгээ, газар дээр нь хүргэн ажилласан.

Биеийн тамир, спортын чиглэлээр: Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор жил бүр зохион байгуулагддаг 21 аймгийн аварга шалгаруулах “Үндэсний цом-2019” хөлбөмбөгийн

тэмцээнд Сүхбаатар аймгийн насанд хүрэгчдийн шигшээ баг түрүүлж, анх удаа аваргын цом гардан авлаа. Тэмцээнд Сүхбаатар аймгийн шигшээ баг 7 дахь удаагаа оролцож байгаа бөгөөд өмнө нь хоёр удаа шагналт дөрөвдүгээр байрт шалгарч байсан юм.

Тус аймгийн баг, тамирчид БНХАУ-ын ӨМӨЗОны Алтан эмээл хотод болсон Жудо бөхийн олон улсын тэмцээнээс 3 алт, 2 мөнгө, 4 хүрэл, Шилийн гол аймгийн Улиастай хотод болсон жудо бөхийн өсвөр үеийн Олон улсын тэмцээнээс 6 алт, 4 мөнгө, 4 хүрэл медаль тус тус хүртсэн байна.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын чиглэлээр: 08-р сарын байдлаар хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй ажил хайгч 840 иргэнээс эмэгтэй 372, бүртгэлтэй ажилгүй иргэн 652 иргэнээс , эмэгтэй 288 иргэн байна. 550 ажлын байрны захиалга бүртгэгдэж, 444 иргэнийг ажилд зуучилсан байна. Ажилд зуучлагдсан иргэдийн 268 иргэн буюу 60 % нь байнгын ажлын байртай болсон байна. Шинээр бий болсон 442 ажлын байрны мэдээллийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, БНСУ-ын хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам хоорондын “хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох” тогтолцооны дагуу БНСУ-д ажилчид илгээх тухай харилцан ойлголцлын санамж бичигт заасны дагуу 16 дахь удаагийн солонгос хэлний түвшин тогтоох шалгалтын бүртгэлийг Сүхбаатар аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт 08-р сарын 06-07-ны өдрүүдэд зохион байгуулан, аймгийн хэмжээнд 20 иргэнийг бүртгэхээс эрэгтэй 11, эмэгтэй 8 нийт 19 иргэнийг бүртгэж, холбогдох мэдээ тайланг тогтсон хугацаанд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлэн ажилласан.

Энэ сард 13 сумын 66 иргэний нийгмийн халамжийн тэтгэмж, 14 иргэний тэтгэвэр, 74 иргэний ахмадын хөнгөлөлт, 12 хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, 0-3 насны хүүхдээ асарч байгаа эхийн 116 хувийн хэрэг, 92 иргэний жирэмсэн эхийн хувийн хэргийг хүлээн авч хянан, нийгмийн халамж үйлчилгээний мэдээллийн системд баталгаажуулсан.

Дөрөв. Хөгжлийн бодлого төлөвлөлт, Дэд бүтэц, Хүнс, хөдөө аж ахуй, газар тариалан, зам тээвэр, уул уурхайн чиглэлээр

Сүхбаатар аймаг дахь Бичигт боомтод 11 га бүхий стандарт шаардлага хангасан гаалийн хяналтын талбайг ашиглалтад орууллаа. Уг ажлыг тус аймгийн "Андын элч" ХХК гүйцэтгэж, 600 гаруй сая төгрөгөөр эрчим хүчний 04 кВт-ын шугам татаж, онлайн сүлжээнд холбох, орох, гарах буюу экспорт, импортын пүүг ГЕГ-ын програмд холбох, хяналтын талбайг хаших, камержуулалт, гэрэлтүүлэг тавих зэрэг ажлуудыг хийж хүлээлгэн өгсөн байна.

Аймгийн Засаг даргын 2019 оны “Барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комисс томилох тухай” А/461 дүгээр захирамжийн дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дарьганга сум 10 ортой эрүүл мэндийн төвийн барилга, Асгат сумын Эрүүл мэндийн төвийн амбулаторийн барилгын гадна шугам сүлжээний угсралтын ажлыг тус тус байнгын ашиглалтанд хүлээж авлаа.

Мал аж ахуйн чиглэлээр: Хөдөө аж ахуйн салбар болон төв суурин газрын 2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах тухай аймгийн Засаг даргын 2019 оны 06 дугаар албан даалгаврыг батлан сумд, байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.

Мал мах бэлтгэлийн судалгааг сумдаас авч нэгтгэн ХХААХҮяаманд явуулсан. Одоогийн байдлаар 623906 мал зах зээлд борлуулж 163790 мал хүнсэнд хэрэглэх тооцоотой байгаа бөгөөд энэ дүн цаашдаа өсөх хандлагатай байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар геофизикийн хайгуулын цэгийг ашиглалт муутай , бэлчээрийн даацыг багасах , ашиглалтыг сайжруулах зорилгоор 44 цэгт 12 суманд хайгуулын ажлыг Ус- амьдрал ХХК –аар гүйцэтгүүлж хайгуулын цэгийг хүлээж аваад байна.

Мал эмнэлгийн чиглэлээр: Аймгийн Засаг даргын 2019 оны А/370 дугаар захирамжийн дагуу “Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх” 3-р ээлжийн вакцинжуулалтыг Эрдэнэцагаан, Асгат, Сүхбаатар, Баруун-Урт сумдын төл мал, Халзан сумын үлдсэн бог малд, 2019 оны А/470 дугаар захирамжийн дагуу Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтыг бүх сумын охин төл малд хийж, дүн мэдээг нэгтгээд байна.

Мөн аймгийн засаг даргын “Мал амьтныг шимэгчтгэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай” 2019 оны А/266 дугаар захирамжийн дагуу 38 аж ахуй нэгжийн эмч, санитарч, туслах ажилтан нийт 60 хүний бүрэлдэхүүнтэй баг гарч бог малыг угаалгын ваннд 2,592,250 малыг угаасан ба хамрагдалт 80,2%, 84800 бод малыг хашаанд шүршиж, хамрагдалт 14,4% байгаа бол мал амьтны эрүүл мэндийн үзлэг тандалтанд 2752960 мянган мал /өссөн дүн / тус тус хамрагдсан дүн мэдээтэй байна.

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ, дархлаажуулалтын ажлыг графикт хугацаанд 13 сумдын 56 аж ахуй нэгжүүдтэй хамтран зохион байгуулж, гүйцэтгэл дүн мэдээг нэгтгээд байна.

Мал эмнэлгийн лаборатори: Гоц халдварт шүлхий, бог малын мялзан өвчний ийлдэс судлалын тандалт шинжилгээний ажлыг 4 сумын 8 багийн 100 өрхийн мал сүрэгт хийж, 1300 дээжийг цуглуулсан ба аймгийн мал эмнэлгийн лаборатори, УМЭАЦТЛ-ийн шинжлэгч эмчтэй хамтран шинжилгээг хийж үр дүнг гаргаад байна. уг шинжилгээнд хамрагдсан дээжийн 155 эсрэг дүнтэй гарч, байгалийн халдварлалт 17.2 %-тай байна.

Мерси Кор ОУБ-тай хамтарсан” Оролцооны Эпидемиологи” дадлагын ажлыг Халзан суманд зохион байгуулж, адууны нийлүүлгийн өвчний тандалт судалгааг хийн 4 багийн 266 өрхийн малчидтай харилцан ярилцаж амжилттай зохион байгуулсан.

Хүнс худалдаа үйлчилгээ, жижиг дунд үйлдвэрлэлийн талаар: БНСУ-ын Наксэн хоршоо нь Монгол Улсад “Загвар хоршоо” байгуулахад хууль эрх зүйн зөвлөгөө, хоршооны хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, мэргэжил дээшлүүлэх болон шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, хөдөө аж ахуйн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн тусалцаа үзүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар Сүхбаатар аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумтай хамтран ажиллах “Санамж бичиг” байгууллаа.

Монголын хоршооллын сургалт, мэдээллийн төв “Тогтвортой хөгжилд залуу хоршоологчдын оролцоо” сэдэвт зүүн бүсийн залуу хоршоологчдын зөвлөгөөнийг 8 дугаар сарын 21-23 –ны өдрүүдэд Дарьганга суманд зохион байгууллаа. Уг зөвлөгөөнд Дорнод, Дорноговь, Хэнтий, Сүхбаатар аймгийн идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй хоршоодын 60 гаруй төлөөлөгчид оролцож, хоршооны бизнесийг удирдах мэдлэг ур чадварыг сайжруулах, хоршооны залуу гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх, өөрсдийн сайн туршлага, шинэ санаачлага, гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр хэлэлцлээ.

Байгаль орчин, аялал жуулчлал, газар зохион байгуулалтын чиглэлээр:

Хог цэвэрлэгээний талаар: Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас зарласан “Хандлагаа өөрчилъе” багц ажлын “Хоггүй, цэвэрхэн монгол” аяны удирдамжийн хүрээнд тус аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар томилсон ба тус ажлын хэсгээс 8 сарыг “Шарилжгүй Сүхбаатар” болгон зарлаж сан ба аянын үйл ажиллагаанд аймгийн ЗДТГ, БОАЖГ, МХГ, Сүхбаатар Төхижилт Үйчилгээ ОНӨААТГ, Буйр нуур мэнэнгийн талын сав газрын захиргаа, Дарьгангын БЦГХЗ, 13 сумын ЗДТГ, 95 ААНБ, сумын иргэд, орон нутгийн BBS, SB, фокус цахим телевиз нэгдэж, оршин суугаа газраа хоггүй, шарилжгүй цэвэрхэн байлгах чиглэлээр хамтран ажиллаж байна. Аймгийн хэмжээнд шарилж устгах ажилд нийт 23 сая төгрөг зарцуулсан бөгөөд нийт 94 ААНБ 3500 иргэн оролцсон байна.

Амьтны аймаг, гамшгийн чиглэлээр: Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутгийн телевизтэй хамтран ажиллах гэрээ хийсний дагуу түймрийн эрсдэл бүхий улиралд анхааруулах санамж шторк орон даяар цацагдаж байна.

Аймгийн БОАЖГазраас Баяндэлгэр, Уулбаян, Сүхбаатар, Эрдэнэцагаан зэрэг сумдын Монгол тарваганд мониторинг хийсэн ба Уулбаян сумын Дэл орчимд 28 толгой тарвага Эрдэнэцагаан сумын Хуран уул, Зотол хаан уул зэрэг газарт хийсэн судалгаагаар нийт 40 толгой тарвага /энэ жилийн төл 9, өнгөрсөн жилийн төл 7 тоологдсон/ тоологдсон байна. Сүхбаатар сумын Баруун зүүн хар ганганд сэргээн нутагшуулсан монгол тарвага өсөн

нэмэгдэж 28 толгойд хүрсэн, Баяндэлгэр сумын Шар дарвай орчимд байршиж байгаа тарваганууд 8 толгой тоологдсон байна.

БОАЖЯамны санхүүжилтээр Сүхбаатар аймгийн Наран, Онгон, Дарьганга, Эрдэнэцагаан, Сүхбаатар сумдын нутагт Гидрогеологийн судалгааны ажлыг хийж байгаа бөгөөд зэрлэг амьтадын усан хангамжийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд 6 цооног өрөмдөж нарны эрчим хүчээр ажилладаг худаг гаргах ажлыг эхлүүлээд байна. Дээрх худгуудыг Наран, Дарьганга сумдын нутагт тус бүр 1 ш, харин Эрдэнэцагаан сумын нутагт 3 ширхэгийг гаргахаар төлөвлөж байгаа ба Эрдэнэцагаан сумын Лхачинвандад уулын Халиун бугын сүрэгт зориулан 2 худаг гаргахаар өрөмдөж байна.

БОАЖЯамны зөвшөөрлөөр Идлэг шонхор барих гадаадын иргэдийн 3 отог 5 шонхор шувуу барих гэрээ, Баяндэлгэр сум мөн 5 шонхор шувуу бариулах гэрээг тус тус хийсэн байна. аймгийн БОАЖГазраас Мөнххаан сумын Цээлд байрлаж байгаа отгоор орж хяналт шалгалтыг хийхэд тухайн сумтай гэрээ байгуулахаас өмнө 50ш ногтруу, 50ш тагтааг барьсан байсныг илрүүлж, холбогдох журмын дагуу сумын Засаг даргатай гэрээ байгуулсан. Одоогийн байдлаар 6 шонхор, 123 шувуунд гэрээ байгуулсан. Тагтаа, ногтрууны 1.9 сая төгрөг, шонхор шувууны 12.8 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэн ажиллаж байна.

Тав. Батлан хамгаалах чиглэлээр

Хилийн 0146 дүгээр анги улсын хилийн хариуцсан хэсэг болох Бичигт, Адуунчулуун, Халтар хошууны хэсэгт улсын төсвийн 300.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хилийн торыг бүрэн шинэчилсэний зэрэгцээ хянах зурвас, төмөр хянах цамхаг, хилийн хөдөлгөөнт харуулын байр зэргийг шинээр барьж төхөөрөмжлөн, ашиглалтад орууллаа.

Зургаа. Сумд

Баруун-Урт :

Эрүүл мэндийн чиглэлээр: Сумын Засаг даргын 2019 оны А/137 дугаар захирамжаар 20 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг гарч энэ сарын 12-16-ны өдрүүдэд 8-р багийн өдөрлөг, явуулын амбулаторийн үзлэг шинжилгээг 5 хэсэгт зохион байгуулсан ба нийт 318 иргэнд дотрын эмчийн үзлэг, ЭХО, БЗДХалдвар, урьдчилан сэргийлэх үзлэг зэрэг амбулаторийн үйлчилгээг үзүүлж, төрийн байгууллагын мэдээлэл хүргэхийн зэрэгцээ иргэдийн санал хүсэлтийг авч ажиллалаа.

Нийгмийн халамж, хамгаалал, төсөл хөтөлбөрийн чиглэлээр: Дуусашгүй ухаан ТББ-аас 2019-2020 оны хичээлийн шинэ жил эхэлж байгаатай холбогдуулан зорилтот бүлгийн 9 өрхийн хүүхдүүдийг хичээлийн хэрэгсэл, хувцсаар хангасан ба 3 ээжид орон нутгийн гоо сайхны салоноор нэг удаа үнэ төлбөргүй үйлчлүүлэх болон хичээлийн бэлтгэл хангахтай холбоотой эрхийг 4 хүүхдэд тус тус олголоо.

Хөдөө аж ахуй, газар тариалан, жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр: Төл малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт хийх ажлыг Аймгийн засаг даргын А\370, сумын засаг даргын А\127 дугаар захирамжуудын дагуу эхлүүлж, 5 групп ажилласан ба 91359 төл малд вакцинжуулалт хийж, ариутгал халдваргүйжүүлэлт 80 мкв талбайд хийгдсэн байна.

Байгаль орчин, дэд бүтэц, газар зохион байгуулалт, хот тохижилтын хүрээнд: Шарилжтай тэмцэх ажлын хүрээнд Орон нутаг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр Баруун-Урт сумын нийтийн эзэмшлийн зам талбайн шарилж цэвэрлэгээний ажилд иргэдийг түр ажлын байраар хангах, ПИЙЛ ХИЛЛ нөхөрлөлтөй 20.0 сая төгрөгийн санхүүжилттэй гэрээ байгуулж, шарилж цэвэрлэгээний ажилд хяналт тавьж ажиллалаа.

Баруун-Урт суманд Орон нутаг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 7-р багийн нутаг дэвсгэр дэх Жаргалан хотхоны 103-р байрны дээвэр засвар, тус багийн нийтийн эзэмшлийн орон сууцны дундах бетон зам талбайн тохижилт, 8-р багийн нутаг дэвсгэрт байрлах Хайлааст үүдэн, Шовдол зэрэг газруудад 2 гүн өрмийн худаг гаргах, тус багийн нутаг дэвсгэр дэх агропаркыг тохижуулах зэрэг ажлуудыг гүйцэтгүүлж, явцад хяналт тавин ажиллалаа.

Дарьганга сум:

Төрийн удирдлагын чиглэлээр: 2020 онд явагдах Хүн ам, орон сууцны болон байшин орон сууцны 2019 оны тооллогуудын бэлтгэл ажлыг эрчимжүүлэх зорилго бүхий аймгийн Засаг даргын 2019.8.07 ны өдрийн 05 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Хөрөнгө оруулалт, хөдөө аж ахуй, дэд бүтэц, байгаль орчны чиглэлээр: Сумын Засаг даргын 2019.08.13 ны өдрийн А/84 дүгээр захирамжаар хадлан бэлтгэх иргэн, аж ахуйн нэгж байгууллага тус бүрийн хадлангийн зориулалтаар ашиглах “га” талбайд ургамал ашигласны төлбөрийг хэмжээг тогтоож, нийт 13 хүнээр 13,650,000 төгрөгийн төлбөрийг төлүүлэхээр шийдвэрлээд байна.

Сумын засаг даргын 2019 оны А/81 дүгээр захирамжийн мал сүргийг угаалганд хамруулах ажил хийгдэж эхлээд байна. Одоогоор 60,000 бог малыг хамруулаад байна.

Малын чанарыг сайжруулах ажлын хүрээнд бог малын хээлтүүлэгчийг худалдан авах ажлыг зохион байгуулж 100 толгой бог малын хээлтүүлэгчийг ОНХСангийн 5.0 сая төгрөгийн санхүүжилтээр “Уянга цайдам” хоршоогоор гүйцэтгүүлээд байна.

БОАЖГазар болон бусад чиглэлийн байгууллагатай хамтран “Хоггүй, цэвэрхэн монгол” аянд нэгдэж 8 сарыг “Шарилжгүй Сүхбаатар” аяны сар болгон ажил өрнүүлсэн. Энэ ажлын хүрээнд ТХГН-т Орчны бүсийн сумдын албан газар, ААНБ, айл өрх бүрийг өөрийн эзэмшлийн гудамж талбайн шарилжыг цэвэрлүүлэх ажлыг хийж эхлээд байна. Энэ хугацаанд тусгай хамгаалалттай газар нутаг болон Орчны бүсийн их цэвэрлэгээний ажлыг 2 удаа зохион байгуулж, Алтан –Овоо, Шилийнбогд, Гангануур, Тооройбанди, Хөргийн хөндий болон Зэгст нуур, Дуут нуур, Дагшин гол зэрэг газруудын хог хаягдлыг цэвэрлэж нийт 6 тн хогийг зөөвөрлөж хаясан

ТХГНутаг болон Орчны бүсэд тархсан биологийн төрөл зүйлийн тархац, тоо толгойд хяналт тавих зорилгоор Шилийн богд, Ачаа, Гурван хүрээт, Хэрээгийн бүдүүн, Дөш, Өнцөг, Тариалан, Энгэрийн ухаа, Талын ухаа Улаан нуур, Хулгарын гуу, Оргил, Хонгорын энгэр зэрэг газруудаар 7 удаагийн эргүүл хяналт шалгалтыг хийсэн ба э. зөрчил гарах эрсдэл ихтэй газруудад нутаглаж буй малчдад эрх зүйн зөвөлгөө, мэдээллийг өглөө.

Ганга нуурын бохирдол ширгэлтээс хамгаалах урсацыг сайжруулах төслийн хүрээнд 2019 онд Ганга нуурт хийгдэх ажлын төлөвлөгөөний саналыг БОАЖЯ-нд хүргүүлсэний дагуу энэ сарын 5-7-ны өдрүүдэд УБ хотоос тендерт шалгарсан Шимт газар ХХК-ны ажлын хэсэг ирж нөхцөл байдалтай танилцаж, холбогдох албаны хүмүүстэй уулзаж санал солилцон хамтран ажиллахаар боллоо.

Сургалт, сурталчилгааны ажлын чиглэлээр: Авлигатай тэмцэх газрын дэргэдэх “Олон нийтийн зөвлөл”-ийн тэргүүн Г.Баасангаар ахлуулсан 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ажиллаж, 54 иргэнд “Авлигын эсрэг хууль”-ийн хүрээнд мэдээлэл өгч, асуултад хариулт өгч, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авлаа.

БОАЖЯ-наас хэрэгжүүлж буй “ХАНДЛАГАА ӨӨРЧИЛБЭ” багц ажлын хүрээнд хамгаалалтын захиргаанд сар бүр нутгийн иргэд, малчид, жуулчдад зориулж байгаль эх дэлхийгээ хайрлан хамгаалах, уул усыг зөв шүтэх талаар иргэдийн байгаль орчинд хандлагыг өөрчлөх нөлөөллийн ажлын шат дараатай зохион байгуулж байна.

Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын чиглэлээр: Тус суманд 10 ортой эрүүл мэндийн төвийн шинэ барилга ашиглалтад орлоо. Уг барилгыг улсын төвсийн 915.6 сая төгрөгийн санхүүжилтээр “Хөх хайрхан трейд” ХХК гүйцэтгэсэн ба гэрээний хугацаанаас 2 сарын өмнө барилгыг улсын комисст хүлээлгэн өглөө.

“Жаргалан” хүүхдийн сувиллыг 2 ээлжээр ажиллуулж, нийт 12 хүүхдийг сувилж байна.

Мөнххаан:

Хөрөнгө оруулалт, дэд бүтэц, байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр: Мөнххаан сумын 3 дугаар /Баянцагаан/ багийн төвийг ашиглалтанд оруулж, 08 сарын 14-нд багийн төвийн нээлтийн үйл ажиллагааг зохион байгууллаа.

Шарилжгүй Мөнххаан аяны хүрээнд албан байгууллага 4, ААН-12, 1 ногоон байгууламж, болон 57 айл өрхийн 126 хүн хашааны шарилж болон өөрийн эзэмшил газрын 50м-ийн доторх шарилж болон хог хаягдлыг цэвэрлэсэн байна.

Наран:

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд хадлангийн 3 салаа 19 хүний бүрэлдэхүүнтэй Монгол-Хятад 2 улсын хилийн торны дотор 48000 мкв талбайд хадлан хадаж эхэлсэн.

Малын угаалганд 50 өрхийн 81350 толгой бог угаалганд хамрагдаад байна.

Хүүхдийн цэцэрлэг сургуулийн өмнөх боловсрол эзэмших хүүхдийн бүртгэлийг хийсэн ба холимог ангид-25, дунд бүлэгт-25, ахлах бүлэгт-30, бэлтгэл ангид-30 хүүхэд суралцахаар бүртгүүлээд байна.

Сүхбаатар:

Төрийн удирдлагын чиглэлээр: Сумын ИТХурал, ЗДТГазраас Монгол Улсын Хөдөлмөрийн баатар Навааншаравын Осгоны “Хөдөлмөрийн баатар” цол хүртсэний 30-н жилийн ой, Хавхаастайн тасгийн саальчдын хөдөлмөр алдрыг тэмдэглэх баяр наадмыг зохион байгууллаа. 1982 онд Н.Осгон, Г.Сумъяа нараар ахлуулсан 9 саальчин эмэгтэй Хавхаастай тасгийн гавшгай бригадыг байгуулж, нэг үнээнээс 1073-1200 литр сүү сааж, улсын төлөвлөгөөг 7300-10300 литр сүүгээр давуулан биелүүлж ажиллаж байжээ. Ийнхүү 1981 онд БНМАУ-ын хошой аварга малчин, 1989 онд Монгол Улсын Хөдөлмөрийн баатар болжээ. МУ-ын хэмжээнд Хөдөлмөрийн баатар цол хүртсэн 11 саальчин байдаг бөгөөд Сүхбаатар аймгийн 77 жилийн түүхэнд хөдөлмөрийн баатар ганц эмэгтэй төрөн гарсан нь Навааншаравын ОСГОН юм. Хүндэтгэлийн арга хэмжээнд аймгийн Засаг дарга Ж.Эрдэнэбаатар оролцож, МУ-ын Хөдөлмөрийн баатар, Д.Сүхбаатарын хошой одонт, Алтан гадас одонт, БНМАУ-ын хошой аварга малчин Навааншаравын ОСГОН-д аймгийн Засаг дарга, Тамгын газраас 5.0 сая төгрөг олгохоор боллоо.

08.12-нд 1,5-р баг, 08.25-нд 2-р баг, 08.28-нд 4-р багийн “Нээлттэй хаалганы өдөрлөг”-үүд тус тус зохион байгуулагдсан. Уг өдөрлөгүүд дээр сумын ЗДТГ-аас томилогдсон ажлын хэсгүүд очиж хөдөөгийн иргэдэд төрийн үйлчилгээг үзүүлж ажилласан байна.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр: Бүгд Найрамдах Солонгос Улсын Наксэн хоршоо нь Монгол Улсад “Загвар хоршоо” байгуулахад хууль эрх зүйн зөвлөгөө, хоршооны хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, мэргэжил дээшлүүлэх болон шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, хөдөө аж ахуйн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн туслалцаа үзүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар Сүхбаатар аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумтай хамтран ажиллах “**Санамж бичиг**” байгуулаад байна.

Энэ сарын 25-нд Алдарт хурдан Нийгмийн хонгор морины нэрэмжит "ДАРХАНХААНЫ ИХ ХҮЛГҮҮД" цогцолборын нээлт, Нийгмийн хонгор МСУХ-ны 10-н жилийн ойн баяр наадам зохион байгуулагдлаа.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, спорт, Эрүүл мэндийн чиглэлээр: Дорнод аймагт зохион байгуулагдсан Зүүн бүсийн хурд баяр наадмын Үндэсний сурын харваа чуулга харваанд сумын "Жанжны нутгийн харваачид" баг амжилттай оролцож өсвөрийн сурын харваанд Г.Тэмүүжин тэргүүн байр эзэлж аймгийн "ӨСӨХ ИДЭР МЭРГЭН" цол, Ц.Мишээл 5-р байр, Ц. Ган-Өлзий МУ-ын 2-р зэрэг, Б. Эрдэнэбат МУ-ын 3-р зэрэг тус тус хүртсэн байна.

Сумын Засаг даргын захирамжаар эрүүл мэнд, боловсролыг дэмжих сангаас 1,4 сая төгрөгөөр зорилтот өрхийн 3-аас дээш хүүхэд нь ЕБС-д сурч байгаа 20 өрхийн хүүхдэд тус бүр нь 70,000 төгрөгийн үнэ бүхий хичээлийн хэрэгслийн тусламж үзүүллээ.

Түвшинширээ:

Төрийн удирдлагын чиглэлээр: ХАОС-ны 2020 оны улсын ээлжит тооллогын бэлтгэл ажлын хүрээнд Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас боловсруулсан “Хаягийн зураг”-т дүрслэгдсэн сууцанд байнга хүн амьдардаг эсэх, “Хаягийн зураг”-т дүрслэгдээгүй сууцыг шинээр тэмдэглэх байдлаар урьдчилсан бүртгэлийн зураглалыг боловсруулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Урьдчилсан бүртгэлд сумын нийт 966 өрх хамрагдсанаас сумын төвд- 387, хөдөөд-484, бусад аймаг суманд-95 өрх тус тус бүртгэгдээд байна.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр: Тус сумын нутгаас байгалийн өнгөт чулуу түүсэн 4 иргэний зөрчлийг таслан зогсоож Зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ авч ажилласан.

Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлын хүрээнд 5 багийн нийт 21 цэгийн 63 хэсгээс ургамлын дээж авч, орчны 84 фото зураг, метрийн заалттай 189 фото зураг, нийт боловсруулалтанд ашиглах 273 фото зураг авсан байна. Мөн хөрсний механик бүрэлдэхүүн тодорхойлох хөрсний зүсэлтийн ажлыг 5 цэгт хийж гүйцэтгэлээ.

50 үнээний тасгийг “Мөнхманлай” БАХ-ийн ахлагч Ц.Батнайрамдал 3 саальчны хамт зохион байгуулан үйл ажиллагааг нь эхлүүлээд байна.

Хууль, эрх зүйн чиглэлээр: Сум хөгжүүлэх сангаас авсан зээлээ төлөөгүй 5 иргэний материалыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хүргүүлж хэргийг дахин нээлгэсэн. Тус сангаас зээл авч хугацаандаа төлөөгүй иргэдээс зээл төлбөрийг барагдуулах чиглэлээр аймгийн ШШГХэлтсийн албан хаагчид ирж ажилласан ба 2 иргэн 4,6 сая төгрөгний төлбөрийг бүрэн төлж гэрээгээ хаасан. 3 иргэн төлөлтөөс 9 сая төгрөгний төлбөрийг барагдуулсан байна. Зээлийн үлдэгдлээ бүрэн төлөөгүй байгаа иргэдтэй харилцан тохиролцож 6 иргэнээс 26,4 сая төгрөгийг төлүүлэх гэрээ байгууллаа.

Түмэнцогт:

Төрийн удирдлагын чиглэлээр: Сумын Засаг даргын 2019 оны А\50 дугаар захирамжийн дагуу “Өвөлжилтийн бэлтгэл ажил хангуулах” ажлыг зохион байгуулж эхлээд байна.

Төрийн албан хаагчдын эрэлт, хэрэгцээнд тулгуурлан “Түмэн 25” айлын орон сууцны барилгыг “Яруу цамхаг” ХХК бариж эхлээд байна.

Дорнод аймгийн Хөлөн буйр, Булган, Матад сумдын нутагт 7 хадлангийн салаа гарч хадлан бэлтгэлийн ажлыг эхлүүлээд байна.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр: Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор уст цэг тогтоох геофизикийн хайгуулын ажлын хэсэг ажиллаж сумын 2 багийн 4 цэгт хайгуул хийж цэг тэмдэглэгээ хийсэн.

Уулбаян:

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр: Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайтай хамтран ажиллах гэрээний дагуу Сун хун гоулд, Шинэ уужим орд ХХК-аас тус бүр 25.0 сая төгрөг орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлсэн.

Сун хун голд ХХК-ны техникийн тусламжтайгаар сумын төвийн газарт орсон барилгуудын туурийг цэвэрлүүлэх, нэгдсэн хогийн цэгийг чөлөөлөх ажилд орон нутгийн хөрөнгөөр 2204,000 төгрөг зарцууллаа.

Жишиг хорооллын ундны усны худагт “Монвекум” ХХК 9,6 сая төгрөгөөр цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулсан.

Хууль, эрх зүйн чиглэлээр: Олон нийтийн мэдээллийн цагаар Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төслийн талаар, Сум хөгжүүлэх сангийн журам, Угийн бичиг хөтлөх журам, Нийгмийн даатгалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаар эрх зүйн сургалт 4 удаа сургалт хэлэлцүүлэг зохион байгуулж 256 иргэн хамрагдсан.

Сар бүрийн 1,11,21,31-нд архи, согтууруулах ундаа худалдахыг хориглосон сумын Засаг даргын захирамжийн хэрэгжилтэд 8 сард Цагдаагийн хэсэгтэй хамтарч шалгалт явуулахад зөрчил илрээгүй байна.

Халзан:

Төрийн удирдлагын ажлын чиглэлээр: Сумын төвийн гудамж талбай, олон нийтийн газар, байгууллага, аж ахуй нэгжийн гадна орчинд үйлдэгдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчил, аюул ослоос урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, иргэд олон нийтийн аюулгүй

байдлыг хангах зорилгоор камержуулалтын ажлыг Улаанбаатар хотын "Хас байгаль" ХХК ОНХСангийн санхүүжилт болох 10,0 сая төгрөгийн төсөвт өртөгөөр хийж гүйцэтгэн хүлээлгэж өглөө.

Тус сумын нутаг Жарын овоо гэх газар үүрэн харилцааны оператор "G mobile"-ын сүлжээг ашиглалтад орууллаа. Ингэснээр хөдөөгийн малчид, иргэд мэдээ мэдээллийг шуурхай авах, солилцох, 3G сүлжээнд холбогдох, орчин үеийн гар утас ашиглах боломж нөхцөлөөр хангагдаж байгаа юм.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Мал эмнэлгийн чиглэлээр: Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад 116753 бог мал хамрагдаж нийт бог малын 93,4 хувийн гүйцэтгэлтэй хийгдлээ.

8 сарын 9-ний өдөр "Малчид уяачдын зөвлөгөөн"-ийг зохион байгуулж, нийт 108 малчид уяачид хамрагдлаа. Тус зөвлөгөөний үеэр Улаанбаатар хотын Ви Ти Нет ТББ, Аймгийн мал эмнэлгийн газрын малын эмч нартай хамтран адуунд тохиолддог халдварт өвчнүүд, түүнээс урьдчилан сэргийлэх, адууны хөлийн догол, дэлүүтэх, адууны шүдний эмгэг, МЭ-ийн үйлчилгээний ач холбогдолын талаар сургалт хэлэлцүүлэг зохион байгуулж, малын эм, тариа, багаж хэрэгсэлийн үзэсгэлэн худалдаа, рентген зураг авах, үзлэг шинжилгээ зэрэг үйлчилгээг үзүүллээ.

3-р багийн БИНХ-аас мал угаалгын ваннтай болох санал гаргасаны дагуу сумын засаг даргын нөөц сангаас 1,000,000 төгрөгний буцалтгүй тусламж үзүүлж мал угаалгын ваннтай болголоо.

Бог малын угаалга 4 хэсэгт хийгдэж 36700 мал хамрагдаад байна.

Орон нутгийн захиалгат тарилганд шөвөг яр 2760, дуут хавдар 795 галзуу 4171 боом 6107 ДХХ энтробактериоз 24206 нийт 38039 мал хамрагдаад байна.

ЖДҮйлдвэр, Сум хөгжүүлэх сангийн чиглэлээр: Энэ сарын 21-ний байдлаар шинээр 3 зээлдэгчид нийт 14200000 мянган төгрөгний зээл олгоод байна. СХСангийн зээлийн эргэн төлөлт 71,5 хувьтай байна.

Байгаль орчны чиглэлээр: Аймгийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө гарган, сумын 12 албан газар, аж ахуй нэгжүүдэд үерийн аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийг хүргүүллээ.

8-р сарын 09-ний өдөр зохион байгуулагдсан "Оюутан нэг өдөр" өдөрлөгийн үеэр оюутан сурагчдад хог хаягдлын талаар сургалт зохион байгуулж, 20 оюутан сурагч, сумын Байгаль орчны тасагтай хамтран сумын төвийн урд талын хог хаягдлыг түүж 5 тн хогийг төвлөрсөн хогийн цэгт зөөвөрлөн хаясан.

